

**АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР БОЛОВСРОЛЫН САЛБАРТ
АЖИЛЛАХ УДИРДАМЖ**

2016 оны 3 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг. Зорилго

Хөндлөнгийн шинжээчдийн багаас хийсэн “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа”-ны 2015 оны үнэлгээгээр Боловсролын яам 28 оноогоор, төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2014 оны судалгааны үр дүнгээр боловсролын байгууллагын шударга байдлын түвшиний үнэлгээ 0.03 пунктээр тус тус буурсан, сургуулийн өмнөх боловсрол олгох цэцэрлэг, болон бага, дунд, дээд боловсролын үйл ажиллагаатай холбогдох иргэдийн гомдлыг бууруулах зорилгоор тус салбарын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг нь дээшлүүлэх, энэ чиглэлээр зөвлөх, арга зүйн удирдлагаар хангах.

Хоёр. Ажиллах чиглэл

2.1. Төрийн болон төрийн бус байгууллагаас явуулсан судалгаа, шинжилгээний дүнг танилцуулах ажлын хүрээнд:

2.1.1. Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны үнэлгээ дүн /”MDS and KhanLex” ХХН, “Хөгжлийн санаачилга бодлого судлалын төв” ТББ, 2015 он/;

2.1.2. Шударга байдлын түвшний үнэлгээ /АТГ, 2016 он/

2.1.4. “Боловсролын салбарын авлигад өртөх эрсдэлийн судалгаа”-ны /2016 он/ дүнг тус тус танилцуулна.

2.2. Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах, сургалт зохион байгуулах ажлыг зорилтод бүлэгт чиглүүлэн ажиллах хүрээнд:

2.2.1. төрийн албан хаагчдад;

2.2.2. иргэний нийгмийн байгууллагуудад;

2.2.3. боловсролын үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдэд;

2.2.4. сурталчилгааны материал, гарын авлага түгээх;

2.2.5. хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулж ажиллана.

2.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангах, заавар зөвлөмж өгөх ажлын хүрээнд:

2.3.1. Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангах;

2.3.2. “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-д тусгасан шалгуур үзүүлэлтийг хангахад чиглэсэн заавар, зөвлөгөө өгөх;

2.3.3. боловсролын салбарт мөрдөгдөж буй дүрэм журам, зааврыг хянан үзэж, холбогдох арга хэмжээг авах;

2.3.5. иргэд, байгууллагаас тус салбарт холбогдох асуудлаар АТГ-т хандаж ирүүлсэн гомдол, мэдээллийн талаар судлан үзэх;

2.3.6. АТГ-ын мөрдөн байцаагчаас хүргүүлсэн “Мэдэгдэл”, зөрчил арилгуулах чиглэлээр хүргүүлсэн албан бичгийн мөрөөр холбогдох арга хэмжээг авах;

2.3.7. байгууллагын болон салбарын хэмжээнд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг шинжлэн үзэж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх ;

2.3.8. эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ныг мэдээлэл, арга зүйгээр хангах зэрэг болно.

2.4. Дээрх чиглэлээр төрийн байгууллагуудаас хийж буй үйл ажиллагаа, үр дүнг дээшлүүлэх, иргэд олон нийтэд хүргэх хүрээнд:

2.4.1. Удирдамжийн 2.1-2.3, 2.4.2-2.4.4-т заасан үйл ажиллагааны талаар байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулах;

2.4.2. хэвлэл мэдээллийнхэн, олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах;

2.4.3. үйл ажиллагааг дээд шатны байгууллага, удирдах албан тушаалтанд танилцуулах, анхаарах асуудлын талаар зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах;

2.4.4. боловсролын үйлчилгээг ил тод, нээлттэй болгосон олон улсын сайн туршлагыг судлан үзэх, нэвтрүүлэх санаачилгыг хэрэгжүүлэх;

2.4.5. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах болон илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Гурав. Хамрах хүрээ

3.1. Боловсролын яам, зохион байгуулалтын бүтцийн нэгж;

3.2. Нийслэлийн дүүргийн сургуулийн өмнөх боловсрол олгох цэцэрлэг;

3.3. Нийслэлийн дүүргийн ерөнхий боловсролын болон лаборатори сургууль;

3.4. Нийслэлийн төрийн өмчит болон төрийн бус өмчийн их, дээд сургууль;

Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа

4.1. 2016 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллана.

Тав. Ажиллах бүрэлдэхүүн

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Л.Батбаяр, ажилтан, комиссар Ж.Сарангэрэл, Б.Туул, Г.Үүрцайх нар ажиллах ба ажиллах чиглэлийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн даргаар батлуулан явцын хэрэгжилтийг тухай бүрт нь тайлагнаж ажиллана.

Зургаа. Тайлагнах

Боловсролын салбарт ажилласан тухай тайланг илтгэх хуудсаар 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Газрын удирдлагад танилцуулна.

Танилцсан: Тамгын хэлтсийн дарга,
эрхэлсэн комиссар

З.Баасанням

Хянасан: Урьдчилан сэргийлэх, соён
гэгээрүүлэх хэлтсийн дарга
эрхэлсэн комиссар

Б.Бат-Отгон

Боловсруулсан: Урьдчилан сэргийлэх, соён
гэгээрүүлэх хэлтсийн ажилтан,
комиссар

Ж.Сарангэрэл